

ДАА

398.245

Д.486


ДЛООН БОР ОГОТНО

Наргантай
влгэд



1992

-Эрт урьд цагт
алгын чинэхэн
нутагтай ах дүү
долоон оготно
байжээ.




398.245
2.486

Алгын чинээ нутагт нь
атгын чинээ цас оржээ.
Тэр цасыг арилгаж
байгаад шагайн
чинээ шар тос
олоод отгон
дүүдээ хадгалуулжээ.




Дүү нь долоосоор байгаад идчихжээ.





Дүүгээ зэмлэж зодоод амь алдуулах
дөхжээ.



Оготнууд энэ тухайгаа мэдүүлэхээр
ноёндоо очиж:

- Алгын чинээ газартай юмсан! гэжээ.
- Яасан том нутагтай юм бэ? гэж гэнэ.
- Атгын чинээ цас орчихлоо! гэжээ.
- Зуд болох шахаа шив дээ! гэжээ.

-Түүнийг арилгаж
байгаад шагайн
чинээ шар тос
оллоо гэжээ.




ДМ-ИМУРА
ТОВЛОРСОН НОМЫН САН
ТЭРГҮҮТ
НОМЫН САН

-Баяжихыг шахаа шив
дээ! гэж гэнэ.



-Түүнийг арилгаж
байгаад шагайн
чинээ шар тос
оллоо гэжээ.

-Баяжихыг шахаа шив
дээ ! гэж гэнэ.



- Түүнийгээ отгон дүүдээ хадгалуулсан юм гэжээ.
- Нярав болох шахаа шив дээ! гэжээ.



-Дүү долоосоор байгаад
идчихжээ гэжээ.

-Мангас болох
шахаа шив дээ!
гэжээ.



-Дүүгээ зодсоор байгаад алчих дөхлөө
гэжээ.

-Дайн болох шахаа шив дээ! гэжээ.



Ноёныгоо ингэж тоомсорлохгүй байхаар нь оготнууд:

- Энэ юу ч мэдэхгүй ноён байна гэж ярьцгаагаад харьж дүүгээ аргадаж эвтэй сайхан амьдрах болжээ.